

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**

2025 оны 09 дүгээр сарын 22

Багануур дүүрэг

Д/д	Зорилго	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Суурь түвшин (2023)	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь	Арга хэмжээний хэрэгжилт	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	Батлагдсан төсөв /сая төгрөг/	Батлагдсан эх үүсвэр	Санхүүжилтийн гүйцэтгэл	Санхүүжилтийн эх үүсвэр	Хариуцах газар
1.2.Бие даасан эдийн засаг бүхий Улсын зэрэглэлтэй хот, дагуул хот																
3		1.2.1.3.Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгана.	3	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих	Дэд бүтцийн ажлын гүйцэтгэл, хувь	20	30			2022-2024 онд Нийслэлийн төсвөөс нийт 1,874.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 110кВ-ийн 6.76 км урт ЦДАШ-ын бүх суурийн ажил хийгдэж, эхний анкер тулгууруудыг босгож дууссан. 2025 онд бүтээн байгуулалтын үлдэгдэл 300.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/197 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар (НХОГ)-т шилжүүлсэн. НХОГ-ын 2025 оны А/21 дугаар тушаалын дагуу 2025.03.14-ний өдөр Паркийн үндсэн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76км цахилгаан дамжуулах агаарын шугамыг Эрчим хүчний барилга байгууламжаар бүртгэн ашиглалтад оруулахаар дараах байгууллагуудын төлөөллийг оролцуулсан техникийн комисс ажилласан. □Захиалагч: НХОГ ОНӨААТҮГ □Зургийн автор: Мон-Энержи Консалт ХХК □Гүйцэтгэгч: Энх өглөө ХХК □Өмчлөгч: Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК □Ашиглагч: БҮТП ХК □Мессе ХХК Техникийн комисс нь улсын комисс ажиллуулахаар шийдвэрлэж дараах бэлтгэл ажлуудыг хангуулсан. - 220/110/35кВ-ын Багануур дэд станцын өргөтгөл, гаргалгаа, релэй хамгаалалт, удирдлагын панель, угсралтын ажил - Шилжүүлэг ажлын хүрээнд таслалт хийх хүсэлтийг ашиглагч байгууллагад хүргүүлэх - Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн зөвлөмжийн дагуу зарим шаардлагатай тоноглолыг захиалан угсрах Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний А/206 дугаар тушаалын дагуу Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын цахилгааны хэлтсийн дарга Д.Батзоригор ахлуулсан Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж шугамыг ашиглалтад хүлээн 110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын нийт төсөв 9,911.6 сая төгрөг бөгөөд Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 50% буюу 4,955.8 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 1,048.9 сая төгрөг тусгагдан батлагдаж дараах шатанд ажил явагдаж байна. - Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. - Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нээгдэж оролцогч 3 байгууллага шаардлага хангаагүй тул Багануур үйлдвэрлэл технологийн паркийн дэд станцын ажил, 110/35/10кВ-ын НХААГ/20250101634/02/01 урилгын дугаартай тендерийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүртэл дахин зарласан.	100	58,600.00	Улсын болон орон нутгийн төсөв	100	Нийслэлийн төсөв	НЗДТГ ХСТХХТ

